



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/442

Улаанбаатар хот

Зарим төсөл, арга хэмжээг
хүчингүй болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/133 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтаар баталсан жагсаалтын 1 дэх заалтын "XVIII.1.56.Эмнэлгийн барилгын гадна цахилгааны шугам /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо/", Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/390 дүгээр захирамжийн хавсралтаар баталсан жагсаалтын 1 дэх заалтын "XIII.1.3.27. Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/" төсөл, арга хэмжээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР